



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Буянт-Ухаа, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17120

Утас: 7128 2064, 7128 2102, Факс: (976) 7004 9825,

Цахим шуудан: info@mcaa.gov.mn,

Цахим хуудас: www.mcaa.gov.mn

АЭРОДРОМ, БҮСИЙН АЖИГЛАЛТЫН
НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ
УДИРДЛАГЫН ДАДЛАГАЖУУРЫГ
ШИНЭЧЛЭХ (УЛААНБААТАР)
ИНЕГ/ХО/20240102023 ДУГААРТАЙ
ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

2024. 10.30 № 01/2410
танай _____-ны № _____-т

Тодруулгын тухай

Тус газраас зарласан Аэродром, бүсийн ажиглалтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг шинэчлэх (Улаанбаатар) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/ХО/20240102023 дугаартай тендерийн бичиг баримтын тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дэх хэсэгт заасан нөхцөлийг магадлахтай холбогдох баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ;

2.Switch буюу сүлжээний тоног төхөөрөмж нь дадлагажуурын тоног төхөөрөмжийн дотоод сүлжээг зохион байгуулахад шаардлагатай төхөөрөмж болно;

3.ТШЗ-ны 18.1-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Мөн тус шаардлагад үнийн дүнгийн шалгуур заагаагүй байгаа нь дээрх хувьчилсан шалгуур хамааралгүй;

4.Техникийн тодорхойлолтын 13.3-т “Захиалагч талын 2 инженерийг угсралт суурилуулалт, тохиргооны үйлдвэрийн сургалтад хамруулна” гэж заасан нь 12.2.3-т заасан 2 инженер техникийн ажилтантай давхцал;

5.Үйлдвэрлэгчийн ажлын байранд манайд нийлүүлэх гэж байгаа тоног төхөөрөмж дээр сургалт зохион байгуулна.

Иймд тендерт оролцогч нарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.3 дахь хэсгийг үндэслэн тодруулгыг цахим системд нээлттэй байршуулж байгааг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

7120 5099